



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 6/19

Ховд

Т.Доржзодовыг гэрээгээр ажиллуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, аймгийн Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн Дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2019 оны А/243 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэнд тавих хяналтыг тогтмолжуулан өр авлагыг бууруулах, мэдээ тайланг гаргах ажлын гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор Санхүү төрийн сангийн хэлтэст харъяалуулан Түмэндэмбэрэлийн Доржзодовыг 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай гэрээт ажилтнаар авч ажиллуулсугай.

2. Т. Доржзодовын гэрээлэн гүйцэтгэх ажлыг тодорхойлон зохих хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулан батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

3. Т.Доржзодовт гэрээт ажил гүйцэтгэсний хөлсөнд 521214 төгрөг /Таван зуун хорин нэгэн мянга хоёр зуун арван дөрөв/, байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 65152 төгрөг /жаран таван мянга нэг зуун тавин хоёр/-ийг тус тус хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтын зардлын санхүүжилтээс сар бүр тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү, аж ахуйн тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД